



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/637

Хэрлэн сум

Урлагийн сэтгэл заслын арга зүйн
сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 20 дугаар хуралдааны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.4.9.1 дэх заалт, Хүүхдийн хөгжил, хамгааллын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2 дахь заалтуудыг хэрэгжүүлэх хүрээнд арт терапи буюу урлагийн сэтгэл заслын сургалт зохион байгуулах зардалд 3,100,000 (гурван сая нэг зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний "Хүүхдэд ээлтэй орон нутаг болно зардал"-аас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023
оны 12 дугаар сарын 13-ны
дугаартай захирамжийн хавсралт

“УРЛАГИЙН СЭТГЭЛ ЗАСАЛ”-ИЙН СУРГАЛТ-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Заалны түрээс	Цаг	16	125.000	2.000.000
2	Цайны материал	Хүн/удаа	100	5000*2	1.000.000
3	Плипчарт цаас	Ширхэг	2	40.000	80.000
4	Бичгийн цаас	Ширхэг	1	20.000	20.000
		Нийт			3.100.000